



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 27 -ны өдөр

Дугаар 1/36

Эрдэнэт

Дотоод хяналтын баг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2011 оны “Нийтлэг журам батлах тухай” 311 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дотоод хяналтын багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, дотоод хяналт зохион байгуулах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын дагуу төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангаж улирал бүр тайлагнахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн Г.Энхжаргалд даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны А/29 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтэс /С.Мөнхзул/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

ЭМГ-ын даргын 2020 оны 09 сарын 17-дрийн
1/Х тоот тушаалын нэгдүгээр хавсралт



Эрүүл мэндийн газрын Дотоод хяналтын багийн бүрэлдэхүүн

Ахлагч :

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн

Гишүүдэд:

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хариуцсан мэргэжилтэн
2. Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
3. Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн
4. Халдварт бус өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн



ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДОТООД ХЯНАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү журам нь байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг Эрүүл мэндийн газрын хэмжээнд дотоод хяналт шалгалт хийхэд дагаж мөрдөнө.

Хоёр. Дотоод хяналт шалгалтын зарчим, зохион байгуулалт

- 2.1 Дотоод хяналт шалгалтын зорилго нь Эрүүл мэндийн газрын хэмжээнд дотоод хяналтыг зохион байгуулах, илэрсэн зарчил дутагдлыг арилгуулах, сахилга дэг журмыг бэхжүүлэх, авилга, хүнд суртлаас сэргийлэх, төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай явуулахад чиглэнэ.
- 2.2 Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх, ил тод, шударга, бодит, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.
- 2.2 Дотоод хяналт шалгалт нь төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус хэлбэрээр явагдана. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг явуулах бол энэ тухай удирдамжид дурдана. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг явуулахдаа оны эхэнд газрын даргаар батлуулж албан хаагчдад мэдээлж ажилласны дагуу явуулна.
- 2.3 Дотоод хяналт шалгалтад ЭМГ-ын холбогдох мэргэжилтнүүдээс татан оролцуулж болно.
- 2.4 Дотоод хяналтын багийн төлөвлөгөөнөөс гадна Эрүүл мэндийн газрын НЭМТ болон хэлтэс тус бүр дотоод хяналтын төлөвлөгөөтэй ажиллах ба хэрэгжилтэд нь Дотоод хяналтын баг хяналт тавьж ажиллана.
- 2.5 Дотоод хяналтын багийн хурал 2/3 оролцсоноор хурлыг хүчинтэйд тооцно.
- 2.6 Дотоод хяналтын багийн хуралд оролцож чадахгүй хүндэтгэх шалтгаан гарвал багийн ахлагчид урьдчилан мэдэгдэж хэлнэ.

Гурав. Дотоод хяналтын багийн эрх, үүрэг

- 3.1 Дотоод хяналт шалгалтыг удирдамжийн дагуу товлосон хугацаанд гүйцэтгэж, дүнг тайлагнах
- 3.2 Хяналт шалгалт явуулахдаа нэгжүүдийн удирдлагатай харилцаж шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгах, илэрсэн зөрчил дутагдлын талаар тайлбар гаргуулан авах

- 3.3 Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг заавал баримтжуулж, баталгаажуулсан байх.
- 3.4 Хяналт шалгалтын явцад олж авсан мэдээллийн нууцыг хадгалах
- 3.5 Дотоод хяналтын дүнд тулгуурлан гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, зохих журмын дагуу биелэлтийг хангуулах арга хэмжээ авах.
- 3.6 Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага тооцох талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлэх.
- 3.7 Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил арилгах, урьдчилан сэргийлэх талаар сургалт явуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.
- 3.8 Хууль тогтоомж, шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг байгууллагын ажилтнуудад сурталчлах
- 3.9 Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх.

Дөрөв. Хяналт шалгалтын үйл ажиллагаа

- 4.1 Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна.
 - 4.1.1 Эрүүл мэндийн газрын хэмжээнд хяналтыг доорхи чиглэлүүдээр хийж гүйцэтгэнэ.
Үүнд:
 - ЭМГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
 - Байгууллагын болон хүний нөөцийн ил тод байдал
 - ЭМГ-т ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
 - Шуурхай хурлын шийдвэрийн хэрэгжилт
 - ЭМГ-т хөндлөнгийн аудит, хяналт шалгалтаас өгсөн үүрэг даалгавар, шаардлагын биелэлт
 - Салбар зөвлөл, комисс, багуудын үйл ажиллагаа
 - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, Эрүүл мэндийн газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын мөрдөлт
 - Олон улсын болон улс, орон нутгийн санхүүжилтээр хийгдэж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилтийн зарцуулалт
 - Байгууллагын өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаа
 - Шаардлагатай бусад хяналт

Тав. Байгууллагын удирдлага, албан хаагчдын үүрэг

- 5.1 Дотоод хяналт, шалгалтын үйл ажиллагааг явуулах үед шаардсан мэдээ, материал, лавлагаа, тайлбарыг байгууллагын бүх албан хаагчид хугацаанд нь гаргаж өгөх

бөгөөд шаардлагатай тохиолдолд ярилцлага, санал асуулга хийхэд оролцох үүрэгтэй.

- 5.2 Дотоод хяналтын багийн гаргасан үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг байгууллагын бүх албан хаагчид хэрэгжүүлэх үүрэгтэй

Зургаа. Дотоод хяналт шалгалтын дүн, Хариуцлага

- 6.1 Хийгдсэн хяналт шалгалтын дүн авсан арга хэмээний талаар Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шаардлагатай бол зохих шийдвэр гаргаж хамт олонд мэдээлнэ.
- 6.2 Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 6.3 Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдүүлнэ.